



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус  
хурал хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5, 76 дугаар зүйлийн 76.1.2, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.5, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 7 дугаар зүйлийн 7.1, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 31-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 09:00 цагт Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газар II байр Д корпус зохион байгуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - а. Нэмэлт хувьцаа гарган олон нийтэд санал болгох тухай
3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг энэ тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталж нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлэх, хурлын зар мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анхны мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг 1 үйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтыг энэ тогтоолын Хавсралт №2-т зааснаар баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.СҮХ-ОЧИР

1522010035